

ШАРГА СУМД 5-Р САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС....

2017.05.26

Баянгол

Бүрэн дунд сургуулийн дуу хөгжмийн багш Э.Алтайбаатар олон ховор үзмэрүүдийг цуглуулан музейдээ өглөө. Энэ үзмэрүүдээр булан байгууллаа.

Олон улсын музейн өдрийг тохиолдуулан 1 болон 9-р ангийн хүүхдүүдэд үйл ажиллагаагаа танилцуулан 9-р ангийн сурагчдын дунд АХА тэмцээнийг зохион явуулж 9а ангийн сурагч Б.Хишигбаяр түрүүлээ.



БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ АЖЛЫГ ХИЙЛЭЭ

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр сумын Эрүүл мэндийн төв, 12-р жилийн сургууль, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэг, ЗДТГазар төрийн 5 төсөвт байгууллагын 25 төрийн албан хаагч, ХААН, Төрийн банк, Мон суль, Магнай Трейд ШТСтанц, Алтай-Улиастай эрчмийн 15 иргэд нийт 40 иргэн 150 ширхэг улиасны суулгацыг наадмын талбай, худагны баруун талын цэцэрлэгт хүрээлэнд суулгалаа.



Мөн иргэн Б.Баатармөнх 20 чацарганы суулгац тариаллаа.

“Цэмцгэр- Шарга”, “Ногоон хөгжил” хөтөлбөрүүдийн төслийг ИТХТэргүүлэгчдээр оруулан батлуулж, холбогдох хөрөнгө санхүүгийн асуудлыг ИТХ-ын ээлжилт хуралдаанаар ОНХСангийн хөрөнгөд тодотгол оруулан батлуулахаар ажиллаж

байна. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн бодлогод нийцүүлэн байгаль орчныг бохирдуулагч нь төлбөр төлөгч байх, ашиглагч нь хамгаалагч байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор хог хаягдлын менежментийг сайжруулах, сумын нийт айл өрхүүд, албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэх, хог хаягдлын хэмжээг бууруулах, байгаль орчны бохирдол доройтлоос хүний эрүүл мэнд хүрээлэн буй орчинд үзүүлэх эрсдлийг бууруулах болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээний бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхэд “Цэмцгэр Шарга” хөтөлбөрийн зорилго оршино.

Сумын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, мод зүлэгний ургах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх арчилгаа, хамгаалалтыг **сайжруулах** ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усалгаа арчилгааг нэмэгдүүлэхэд хариуцан эзэнтэй болгох, ундны худгийн эрүүл ахуй “Ногоон хөгжил” хөтөлбөрийн зорилго оршино.

ЭМЭГТЭЙЧҮҮДЭЭС “ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ МЭНД” УРИАЛГА ГАРГАЛАА

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн 2017 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Хөдөлгөөн эрүүл мэнд” аяны хүрээнд сумынхаа нийт эмэгтэйчүүдийн дунд уриалга гарган дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- “Идэвхтэй хөдөлгөөн-Инээмсэглэл, эв нэгдэл” уриатай “Гар бөмбөг”-ийн нөхөрсөг тэмцээнийг явууллаа. Үүнд нийт 48 эмэгтэй оролцож 1 эмэгтэй 3000 төгрөгийн оролцоог ханган нийт 144000 төгрөг болж үүнээс 50%-ийг тэмцээний шагналд зарцуулан үлдэх 50% болох 72000 төгрөгийг эмэгтэйчүүдийн зөвлөлийн хуримтлалын санд анхны мөнгөн хуримтлалын эх үүсвэр болгон сангийн дансаа нээлээ. Энэхүү тэмцээнд ахмад настан Б.Бурмаа ахлагчтай баг тамирчид 1-р байр, ахмад настан Б.Норжингаамаа ахлагчтай баг тамирчид 2-р байр, Б.Санчирмаа ахлагчтай баг тамирчид 3-р байрт тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан байна.
- “Эрүүл бие-Эрч хүч” уриатай “Өглөөний одод” гимнастикийн үйл ажиллагааг 05 сарын 15-22-ны хооронд өглөөний 06.30 цагаас 07.30 цагийн хооронд зохион байгуулж энэ үйл ажиллагаанд давхардсан тоогоор 103 эмэгтэй хамрагдаж гүйлт, гимнастик хөдөлгөөн хийхийн зэрэгцээ 2 төрлийн бүжгийг багшийн дэглэснээр нийтээрээ хийж сурлаа. Энэхүү арга хэмжээнд ахмад настан О.Байгальмаа, Р.Нарантуяа, Х.Батнасан нарын ахмадууд Н.Нарантуяа, Ц.Отгонбаяр, Б.Бадамцэцэг нарын бүсгүйчүүд маань нэг ч таслалгүй идэвхтэй оролцлоо.
- Мөн “Эрүүл бие-Эрч хүч” уриатай “Flash mob” бүжгийн тэмцээнийг нийт төрийн албан хаагчид, ААНБ-ын ажилтан албан хаагчдын дунд зохион

байгуулж нийт 5 ААНБ-ийн ажилтан албан хаагчид оролцож бүжлээ. Уг тэмцээнд 12 жилийн сургуулийн “Говийн хүүхнүүд” баг тэргүүн байр, ЗДТГ-ын “Сарнай” баг дэд байрт шалгарч Хүүхдийн цэцэрлэгийн “25” баг, ААН-үүдийн төлөөлөл “Залуус” баг, Эрүүл мэндийн төвийн “Инээмсэглэл” багууд удааллаа. Уг тэмцээнийг сумын эрүүл мэндийн салбар зөвлөлөөс хамтран зохион байгуулж шагналын санг гаргалаа. Тэмцээнийг Монгол Улсын баатар М.Жанчивын талбайд зохион байгуулж нээлтийн үйл ажиллагааг өглөөний одод үйл ажиллагаанд оролцож байсан нийт эмэгтэйчүүд маань “бара-бэрэ” бүжгээр эхлүүлж нийт 5 багийн 42 иргэн оролцсон байна.

Энэхүү арга хэмжээний маань үр дүнд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирч, төрийн албан хаагчид ажлын байрандаа чөлөөт цагаараа хийж хэвших бүжгийн хөдөлгөөнтэй болоод зогсохгүй төр төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох иргэд олон нийтийн оролцоо нэмэгдэж байна гэж дүгнэлээ. Өөрчлөлтийг өөрөөсөөр эхэлье уриатайгаар нийт эмэгтэйчүүд маань өглөө бүрийг эртлэн босож дасгал хөдөлгөөн хийж өдрийг эв нэгдэл, эрч хүчээр дүүрэн угтацгааж байна.



Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс зохион байгуулсан энэ арга хэмжээнийхээ талаар мэдээллийг бэлтгэн миний нутаг TV-д хүргүүлсэн.

БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


“Цахим орчин дахь гадуурхал” сэдэвт эссе бичлэг , гар зураг, захидлын уралдааны удирдамжийг хүүхдийн нас сэтгэхүй онцлогт тохируулан сонирхол татахуйц байдлаар гаргаж, анги бүрт хүргэн, нийт сурагчдыг хамруулан зохион байгууллаа.



“Цахим орчин дахь гадуурхал, дээрэлхэл” сэдвийн хүрээнд анги бүрт сургалт зохион байгуулсан.



“Цахим гадуурхал цаашаа” үйл ажиллагааны хүрээнд “Цахим орчин дахь гадуурхал” сэдэвт гар зураг, эссе бичлэгийн уралдааныг 3 сарын 15-наас 4 сарын 6 хүртэл зарлаж, өнөөгийн нөхцөл байдлыг бодит дүрслэл зураг болон эссе бичлэгээр илэрхийлэн гаргалаа.



Үр дүн: “Цахим гадуурхал цаашаа” үйл ажиллагааны үр дүнд “Цахим орчин гэж юу бэ, Цахим хэрэглээг хэрхэн хэрэглэх талаар суралцагчид ойлгож, цахим хэрэглээний явцад тулгамдаад байгаа асуудлыг илрүүлэн, цаашид анхаарах асуудлыг тодорхой болгож өглөө.

Сумын ИТХ-ын санаачилсан дээд голын мод услах, шандын эхний хог цэвэрлэх 2 олон нийтийн оролцоот ажилд сургууль нийтээрээ оролцлоо.



4 сарын 29 буюу монгол бөхөнгийн нэг өдрийг тохиолдуулан сургуулийн өөрөө удирдах байгууллага Сонор, Янзага эко клуб дараах ажлуудыг зохион байгууллаа.

1-5-р ангийн сурагчдын дунд “Бөхөн дахин битгий өвчлөөсэй” гар зургийн уралдаан зарлалаа. Нийт 42 бүтээл ирснээс:

1-р байр 4а ангийн сурагч Ж.Дүүрэнхишиг

2-р байр: 2а ангийн сурагч Г.Энх-Учрал

3-р байр: 5а ангийн сурагч Т.Сүхбат нар тус тус эзэллээ.



“Бөхөн дахин битгий өвчлөөсэй” нэрийн хуудас багш, ажилчид, төрийн албан хаагчдад тарааллаа. Нийт 200 ширхэгийн тараасан.



Дотуур байрны сурагчдын дунд “Бөхөн” сэдэвт хөгжөөнт буухиа тэмцээн, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан. Нийт 50 сурагч хамрагдсан.



1,2-р ангийн сурагчдын дунд “Бөхөн” гэж ямар амьтан байдаг вэ? Сургалт зохион байгууллаа. Нийт 75 сурагч хамрагдлаа.



Эссе бичлэгийн уралдааныг 9-12-р ангийн сурагчдын дунд зарласан бөгөөд нийт 31 сурагч хамрагдаж, өөрийн үзэл бодлоо бодит баримтад тулгуурлан бичсэн байлаа.

1-р байр: 12а ангийн сурагч Л.Энхтуул

2-р байр: 11а ангийн сурагч Г.Цэвэгмэд

3-р байр: 12а ангийн сурагч Э.Энхзаяа нар тус тус эзэллээ.



Эссе бичлэгийн гол үзэл санаа буюу дүгнэлт:

- Эрүүл байгаа газруудаар бөхөнг халдвар авахаас сэргийлж байнгын ариутгал хийх
 - Улсын хэмжээнд хорогдсон бөхөнгийн 27,8% шаргачин, 1,3% ооно эзэлж байна.
 - Ирээдүйд хүй нэгдлийн үеийн гайхамшигийг үлдээх үү, үгүй юу гэдэг хүмүүс биднээс шалтгаална.
1. Бөхөнгийн өдрийн шилдэг зураг, дүрс бичлэгийн уралдаан
 2. Чоно борооноор гэгчээр
 3. Баян байлаа гээд бахархах баялаггүй бол яанам

Бөхөнгийн нэг өдөр анхдугаар наадамд Дарви сумад очиж оролцон дууны төрөлд багаараа 1-р байр, бүжгийн төрөлд 3-р байр, сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй 2-р байр, теннисний төрөлд эрэгтэй эмэгтэй тус тус 1-байр эзэлж, шилжин явах цом, дараа жил зохион байгуулах эрхээр шагнагдлаа.



2016-2017 оны хичээлийн жилийн эрдмийн баярыг тусгай хөтөлбөр төлөвлөгөөний эрдмийн баярын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ.






“Алдаагүй бичигтэн анги” шалгаруулах уралдаан зарлаж, 3а анги шалгарлаа.

С.Сүхбаатарын үг, Э.Хүрэлбаатарын ая Шаргын сургууль дууг хэний анги сайн дуулах вэ? Уралдаан зохион байгууллаа. Бага ангиас 2а 1-р байр, дунд ахлах ангиас 7-р анги шалгарлаа.



“Цэвэр анги цэмцгэр сурагч” 14 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Бага ангиас 1а анги, дунд ангиас 6а анги, ахлах ангиас 10а анги шалгарлаа.





Эрдмийн баярын хүрээнд 5,9,12-р ангийн суралцагчид бүтээлийн үзэсгэлэн гаргалаа.



Мэдээ бэлтгэсэн: Д. Ончимэг